



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

**СҮХБААТАР СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
МОНГОЛ АРДЫН НАМД**

2024.08.05 № ГНАГ-2024/13-МТА-НА-13
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын

018020495

нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Монгол Ардын намын Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт арга, хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сүхбаатар сумын Монгол Ардын намын мөрийн хөтөлбөр (*12* хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Сүхбаатар сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР




Ч.ЭНХТУЯА

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД,
СҮХБААТАР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМААС УИХ-ЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2024.06.15

СҮХБААТАР СУМАА
“ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ”



Монгол улсын хөгжлийн “Алсын хараа- 2050”, “Шинэ сэргэлт”-ийн бодлогын баримт бичгийг үндсэн чиглэл болгон Монгол Ардын Намаас УИХ-ын 2024 оны сонгуульд дэвшүүлсэн хөгжлийн бодлого, Сэлэнгэ аймгийн Монгол Ардын Намаас 2024 оны аймгийн ИТХ-ын сонгуульд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийгэм эдийн засгийн хөгжлийг хурдасгах чиглэлээр өмнө нь хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээний үр дүнд тулгуурлан

- Иргэдийнхээ ая тухтай амьдрах орчинг сайжруулах
- Эдийн засгийн өсөлтийг хангаж, өрх бүрийн амьдралд үр шимийг нь хүртээх зорилгоор орон нутгийнхаа иргэд, аж ахуйн нэгж байгууллага, иргэний нийгмийн байгууллагаас гарсан санал санаачилгуудыг судлан үзэж, нэгтгэн тусгасан мөрийн хөтөлбөрөө Сонгогч олондоо өргөн барьж байна.

МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА:

1. БОЛОВСРОЛ, СОЁЛ
2. ЭРҮҮЛ МЭНД
3. БИЕИЙН ТАМИР, СПОРТ
4. ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЭЦ
5. ГЭР БҮЛ
6. БАЙГАЛЬ ОРЧИН-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
7. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ
8. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ
9. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ

НЭГ. БОЛОВСРОЛ, СОЁЛ



1.1 Боловсрол

Боловсролтой иргэн - Монголын ирээдүй

- 1.1.1 Өсвөр үеийнхнийг эх оронч үзэлтэй, их түүхээ судалж, уламжлалт өв соёлоо дээдэлсэн, “Зөв хүн” болгон төлөвшүүлэх бага, дунд боловсролын чанарыг дээшлүүлэхэд боловсролын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлж, хүүхдийн өөрийнх нь авьяаст тулгуурлан хөгжүүлж, амьдралын зөв дадалд сургана.
- 1.1.2 Хүүхэд харах үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлж, 1-2 хүртэлх насны хүүхдийг яслийн үйлчилгээнд хамруулан, ээжүүдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.
- 1.1.3 Хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж, сургуулийн бүлэг дүүргэлтийг норматив хэмжээнд хүргэнэ.
- 1.1.4 Сүхбаатар сумын бүх шатны сургалтын байгууллагад англи хэлийг эзэмших орчныг бүрдүүлж, англи хэлний багш нарыг мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттайгаар хамруулахад хамтарч ажиллана.
- 1.1.5 Сүхбаатар сумын цэцэрлэг сургуулийн орчинг бүрэн камержуулж, хүүхдийн аюулгүй, таатай суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.6 Багшийн ажлын бодит үнэлэмжийг нэмэгдүүлж, мэргэжлийн нэр хүндийг өсгөхийн зэрэгцээ багш нарыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг боловсрол, ур чадвар, хариуцлага, харилцаа хандлагыг нь дээшлүүлнэ.
- 1.1.7 Хүүхдийн тоо, эрэлт хэрэгцээнд уялдуулан цэцэрлэг, сургууль шинээр барих, өргөтгөх, барилга байгууламж, дэд бүтэц, сургалтын тоног төхөөрөмжийг үе шаттайгаар сайжруулж, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.
- 1.1.8 Тусгай хэрэгцээт хүүхдийг сургууль цэцэрлэгт сурах, хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлнэ.
- 1.1.9 Ерөнхий боловсролын сургуулиудын дунд болон гадаад хамтын ажиллагаатай улс, хотуудтай багш, сурагч солилцооны хөтөлбөрүүдийн хүрээнд хамтарч ажиллана.
- 1.1.10 Хүүхэд багачуудыг улсын болон олон улсын чанартай уралдаан, тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, урамшууллын журамтай болгоно.

1.1.11 Сурагч болон багшид сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлэх, сурагчдад мэргэжлээ сонгох, ирээдүйгээ тодорхойлоход нь зөвлөн туслах чиг үүрэгтэй сэтгэл зүйч мэргэжилтнүүдийг сургууль бүрд ажиллуулна.

1.1.12 Хүүхэд залуучуудын оюуны болон бие бялдрыг хөгжүүлэхэд чиглэгдсэн төрөл бүрийн секц, сургалт, дугуйлангийн үйл ажиллагааг дэмжинэ.

1.1.13 Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудад хүүхдийг зөв монгол хүн болгон төлөвшүүлэх, амьдралын зөв дадал хэвшилд сургах үйл ажиллагааг эрчимжүүлнэ.

1.2 Соёл урлаг

Нүүдэлчин соёл - Монголын гайхамшиг

1.2.1 “Монгол хүн”, “Монгол ахуй”, “Монгол соёл”, “Монгол урлаг” бодлогыг хэрэгжүүлж, түгээн дэлгэрүүлнэ.

1.2.2 “Сэлэнгэ-Хувьсгалын өлгий нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, түүхэн дурсгалт газруудыг баримтжуулж орчныг тохижуулж, ард түмэнд түгээн дэлгэрүүлж таниулна.

1.2.3 “Соёлын бүтээлч үйлдвэрлэл III” хөтөлбөрийг хэрэгжүүлж, соёл урлагийн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага, хувь хүний туурвисан бүтээлийг дотоод, гадаадад сурталчлан таниулахад дэмжинэ.

1.2.4 Үндэсний өв соёлоо уламжлан хадгалах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт орсон морин хуурын сургалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1.2.5 Хүүхэд, залуучууд, уран бүтээлчдийг үндэсний соёл, урлагийн чиглэлээр улсын болон олон улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлдэг, амжилтын үзүүлэлтээр урамшуулал олгодог журмыг боловсронгуй болгоно.

ХОЁР. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл бие - саруул ухаан

2.1 Хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд эрүүл мэндийн үзлэг, эрт илрүүлгийг тасралтгүй үр дүнтэй хэрэгжүүлнэ.

- 2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын чанарыг дээшлүүлж, хүүхдийн эрүүл мэндийн үзлэгийг жилд 2 удаа зохион байгуулж эрт илрүүлэх, эрүүлжүүлэх ажлыг чанаржуулна.
- 2.3 Эмч, эмнэлгийн ажилтнуудыг үе шаттайгаар гадаад, дотоодод туршлага судлуулж, давтан сургаж, мэргэшүүлж, мэдлэг, ур чадвар, ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагыг дээшлүүлнэ.
- 2.4 Сүхбаатар сумын өрхийн эрүүл мэндийн төвүүдийн барилгын засвар, тохижилт, өргөтгөл, үе шаттайгаар хийж, техник хэрэгслээр ханган, иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бүх түвшинд шуурхай хүргэх, ая тухтай орчинд оношлох, эмчлэх боломж бүрдүүлнэ.
- 2.5 Сумын хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, эндэгдлийн шалтгааныг судлан тогтоож, урьдчилан сэргийлэх, оношлох, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.6 Иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал хөдөлгөөн, иог, бүжиг, хийн дасгал хийх зэрэг үйлчилгээг авах бололцоо бүхий “Эрүүл зөв амьдрал” төв ажиллуулах хувийн хэвшлийг дэмжинэ.
- 2.7 Ахмадын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх “Ахмадын хөгжлийн төв”-ийг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар байгуулан, ахмадуудыг бие эрүүл, сэтгэл амар, ая тухтай амарч, хөгжих орчин бүрдүүлнэ.
- 2.8 Хүн амын амьдралын зөв дадал хэвшлийг дэмжих, архи, тамхи, мансууруулах бодис, цахим тоглоом болон бусад бүх төрлийн донтолтоос урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлыг тогтмолжуулж бүх нийтийн үйлс болгон зохион байгуулна.
- 2.9 “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд”, “Эрүүл ирээдүй” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 2.10 Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг бүрдүүлэхийн тулд сумын хэмжээнд бүх нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан тэмцээнийг жил тутамд зохион байгуулна.
- 2.11 Сумын хэмжээнд байгалийн гамшиг, онц байдал, цар тахлын халдвар дэлгэрэхээс урьдчилан сэргийлэх дадал хэвшлийг бий болгоно.

ГУРАВ. БИЕЙН ТАМИР, СПОРТ

Сүхбаатарын тамирчид - Олон улсын тавцанд

- 3.1 Иргэдийг идэвхтэй хөдөлгөөн, нийтийн биеийн тамир спортоор хичээллэх сонирхлыг төрүүлэх, орчныг бүрдүүлэх, сайжруулах, эрүүл чийрэг амьдралыг төлөвшүүлэхэд биеийн тамир, спортын салбарын үйлчилгээг чиглүүлнэ.
- 3.2 Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт тусгагдсан шатар, цана, тэшүүрээр хичээллүүлэх дугуйлан, секцийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.
- 3.3 Усанд сэлэлтийн спортыг хөгжүүлж, аймаг, сумын аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулна.
- 3.4 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 3.5 Бүсийн болон аймгийн аварга шалгаруулах “Сэлэнгэ лиг” спортын олон төрөлт тэмцээнийг жил бүр зохион байгуулж, жилд 3-аас доошгүй улсын болон бүсийн аварга шалгаруулах тэмцээнийг сумандаа хүлээн авна.
- 3.6 Сүхбаатар сумын төрийн албан хаагчдын дунд спортын олон төрөлтийн тэмцээнийг жил бүр зохион байгуулна.
- 3.7 Сүхбаатар суманд хөл бөмбөг, хоккейн стандарт талбайтай болсонтой холбогдуулан тухайн спортыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.8 Дугуйн болон явган аяллыг дэмжиж ажиллана.
- 3.9 Тамирчдыг улсын болон олон улс, тив, дэлхийн уралдаан тэмцээнд оролцоход зохих дэмжлэг үзүүлэх дүрэм журмыг боловсронгуй болгоно.

ДӨРӨВ. ҮЙЛДВЭРЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЭЦ

Чанартай үйлчилгээ - Таатай орчин - Сэтгэл ханамж

- 4.1 Үйлдвэрлэл үйлчилгээ
- 4.1.1 Барилгын түүхий эд, материал үйлдвэрлэх санал санаачилгыг дэмжинэ.
- 4.1.2 Төмс, хүнсний ногоо нөөшлөн угааж, савлан боловсруулалт хийх үйлдвэр байгуулах, иргэд, аж ахуй нэгжид дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 4.1.3 Мах, сүү боловсруулах үйлдвэр байгуулан, сумын болон ойролцоох сумдын малчид, мал бүхий иргэдийн мах сүүний борлуулалтыг дэмжиж ажиллана.

4.1.4 Сүхбаатар суманд инноваци нэвтрүүлсэн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл байгуулахыг дэмжин хүн амыг эрүүл, аюулгүй тэжээллэг баталгаат хүнсээр хангадаг болно.

4.1.5 Худалдаа үйлчилгээний сүлжээ дэлгүүрүүдийн салбарыг бий болгоно.

4.1.6 Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжиж ажиллана.

4.2 Дэд бүтэц

4.2.1 Аймгийн ИТХ-аар батлагдсан байршилд барилгын насжилт нь дууссан орон сууцуудыг шинэ орон сууцаар солих, дахин төлөвлөлтийг иргэдийн оролцоотойгоор хийж, хөгжлийн төлөвлөлтийн дагуу орон сууцжуулах төсөл, хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2.2 Хөрсний бохирдлыг бууруулах замаар гэр хорооллын нүхэн жорлонг, эко 00-той болгох зорилгоор, иргэдийг ногоон зээлд хамрагдахад нь банкуудтай хамтран ажиллаж, ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.3 Нийтийн орон сууцны хуучин барилгын гадна фасадыг шинэчлэн засварлах, дулаан алдагдлыг бууруулах ажлыг хувийн хэвшил, иргэдийн оролцоотойгоор хэсэгчлэн хэрэгжүүлэхэд нь дэмжиж ажиллана.

4.2.4 Гэр хорооллын боломжтой хэсгийг инженерийн дэд бүтэцтэй болгох, дахин төлөвлөлтийг хийж, иргэдийг орон сууцжуулах, төсөл, хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлнэ.


4.2.5 Орон сууцны төлөвлөлтөд оршин суугчид амрах, чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгмийн дэд бүтэц, ногоон байгууламж, хүүхдийн тоглоомын талбай, биеийн тамирын талбай, авто машины зогсоол бүхий орчин бүрдүүлэх, стандартыг мөрдүүлнэ.

4.2.6 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох зорилгоор гудамж талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, нийтийн эзэмшлийн талбай, авто замыг бүрэн камержуулан, ард иргэдийн аюулгүй байдлыг хангана.

4.2.7 Үерийн хамгаалалтын далан, сувгийн ажлын хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлж, үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.8 Хот төлөвлөлтийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хот байгуулалтын үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.


4.2.9 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг шинээр боловсруулж, хог хаягдлыг татан төвлөрүүлэх, ангилан ялгах үйлдвэрийг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулна.



4.2.10 Орчны тандалт нөлөөллийн үнэлгээ хийж, агаар хөрс, усны бохирдлыг тодорхойлж, бохирдлын эх үүсвэрийг арилгах ажлыг хэрэгжүүлнэ.

4.2.11 Хотын доторх авто замыг шинэчилж, зарим цэгт өргөтгөн, төмөр замтай огтлолцсон хэсэгт зөөлөн орц, гарцыг хийнэ.

4.2.12 “Цагаан эрэг тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГазрын тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг үе шаттайгаар хийж хэрэгжүүлнэ.



4.2.13 Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр Сүхбаатар хотод 50 МВт-ын дулааны цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулна.

4.2.14 Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсхүл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулж иргэдийн амар тайван орчныг бэхжүүлнэ.

4.2.15 Усан хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийг шинэчлэх, өргөтгөх замаар ард иргэдийг шаардлага хангасан ундны усаар хангана. Шаардлагатай газруудад иргэдэд хүртээмжтэй байдлаар цэвэр усны шугамын тоог нэмэгдүүлнэ.

4.2.16 Орон сууцны цэвэр усны шугамын насжилтад үзлэг хийж, хуучирсан шугам хоолойг дэс дараатай шинэчлэн сольж, ундны усыг эрүүл ахуйн шаардлагад нийцүүлнэ.

4.2.17 Хүүхдийн парк бүхий соёл амралтын цэцэрлэгт хүрээлэн байгуулах асуудлыг улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэнэ.

4.2.18 Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах, төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл зөвлөгөө өгөх төвийг байгуулна.

4.2.19 Хонгор морьтын 1-р баг, Бор гүвээний 5-р баг, Буур хээрийн 8-р багуудад нийтийн тээврийн тогтмол үйлчилгээг бий болгоно.

4.2.20 “Багийн хөгжлийн төв”-ийн байрыг багуудад үе шаттайгаар нэмэгдүүлнэ.

4.2.21 Алслагдсан багуудад стандартын шаардлага хангасан спорт, урлагийн заалыг үе шаттайгаар барьж, ашиглалтад оруулна.

4.2.22 Сургууль, цэцэрлэгийн барилгын өргөтгөл, их засвар, сэргээн засварлах ажлуудыг улсын болон аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

4.2.23 Дугуйн болон явган аяллыг дэмжиж, хот суурин газрын авто замын дагуу явган хүний болон дугуйн замыг байгуулна.

4.2.24 Сүхбаатар сумын “Тусгай хэрэгцээт хүүхдийг сувилан, асрах төв”, “Ахмадын хөгжлийн төв”-ийг байгуулна.

ТАВ. ГЭР БҮЛ- НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

4317143998
МҮА0065 9055436

Жаргалтай гэр бүл - Тайван амьдрал

5.1 Сүхбаатар суманд “Хүүхэд залуучууд, эмэгтэйчүүдийн хөгжлийн ордон” байгуулна.

5.2 Сүхбаатар сумын тусгай хэрэгцээт хүүхдийг сувилан, асран хамгаалах төв, Ахмадын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

5.3 Залуучуудын эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн харилцаа, сэтгэл зүйн хөгжлийн хэрэгцээг дэмжих бодитой хуримтлал бий болгоход чиглэсэн “Залуу гэр бүл” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

5.4 Гэр бүлээрээ болон хувиараа ажил хөдөлмөр эрхлэх, шинэ ажлын байр бий болгохыг дэмжинэ.

5.5 “Миний түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд сумын иргэдэд түрээслэх, түрээслээд өмчлөх орон сууцны төслийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

5.6 Гадаад дотоодын төсөл хөтөлбөр, улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр залуу гэр бүл, ам бүл олонтой айл өрхийг аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.

5.7 Хүүхэд хамгааллын талаар мэдлэг, ойлголт, хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн ажлыг хэрэгжүүлж, хүүхдийг эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.8 Хувь хүн, гэр бүлтэй ажиллах нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн ажиллах орчныг сайжруулна.

5.9 Гэр бүлийн хүчирхийллийг бууруулж, хүчирхийллийг үл тэвчих хандлагыг бий болгох нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлнэ.

5.10 Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх, мэдлэг туршлагаа залуучуудад өвлүүлж үлдээх боломжийг бүрдүүлж, ахмад настны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэгч сум болно.

5.11 Ахмадуудад төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх төвийн үйл ажиллагааг эрэлтэд нийцүүлэн зохион байгуулж, идэвхтэй насжилтыг дэмжинэ.

5.12 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан дэд бүтцийн стандартыг бүх төрлийн орон сууц, худалдаа үйлчилгээний байгууллагуудад мөрдүүлнэ.

5.13 Сүхбаатар суманд 50 мкв цахилгаан станц баригдсанаар айл өрх, албан байгууллагуудыг дулаан, цахилгааны эрчим хүч, халуун усаар жигд найдвартай хангаж ард иргэдийг тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН-АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Ногоон хөгжил - Ногоон аялал

6.1 Байгаль орчин

6.1.1 Байгалийн унаган төрх, биологийн олон янз байдлыг хамгаалж, эко системийн тэнцвэрийг хадгалахад хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах тогтолцоо бүрдүүлнэ.

6.1.2 “Тэрбум мод” үндэсний хөтөлбөрийн хүрээнд гудамж талбай, өрх бүрд ногоон байгууламжуудыг бий болгох замаар цөлжилтөөс хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах ажлыг дэмжиж ажиллана.

6.1.3 Сүхбаатар сумын 4-р багт байрлах чимээгүй хотын орчимд модон хөшиг татаж үзэгдэх орчинг хязгаарлана.

6.2 Аялал жуулчлал

6.2.1 Аялал жуулчлалын салбарыг сумын эдийн засгийн тогтвортой хөгжлийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ.

6.2.2 Аялал жуулчлалын маршрут, зар сурталчилгааг сайжруулж хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

6.2.3 Сум орон нутгийн онцлогт тохирсон брэнд бүтээгдэхүүн, эко аялал, үйлчилгээний нэр төрөл, чанар, дизайныг сайжруулан, хөгжүүлж, нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

6.2.4 Монголын их түүх, соёлын хадгалагдаж үлдсэн өв, байгалийн үзэсгэлэнт газар нутгийг түшиглэсэн эко аялал, жуулчлал болон Орхон, Сэлэнгэ мөрний сав газрын дагуух спорт, экстрим, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

6.2.5 Аялал жуулчлалын бүс дэх хоршоо, нөхөрлөлийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг ногоон зээлд хамруулахад дэмжлэг үзүүлнэ.

6.2.6 Аялал амралт, жуулчлалын чиглэлд дэд бүтцийг сайжруулж, дөрвөн улирлын аялалыг хөгжүүлнэ.

6.2.7 Аялал жуулчлалаар зорин очих газруудад ариун цэврийн байгууламж бүхий түр буудаллах цэг, үйлчилгээний газруудыг байгуулна.

6.2.8 Амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хүүхэд залуусын эрүүл аюулгүй ногоон орчинд аялж зугаалах боломжийг бүрдүүлнэ.

6.2.9 Аялал жуулчлалд зориулагдсан худалдаа, үйлчилгээний гудамжийг байгуулна.

ДОЛОО. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Эрүүл хүнс - эрчимжсэн аж ахуй

Хөдөлмөрч иргэн - чадварлаг хүний нөөц

8.1 Суманд үйл ажиллагаа эрхэлдэг ТББ, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллана.


8.2 Зорилтот бүлгийн өрхүүдэд амьжиргааг дэмжих төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

8.3 Орон нутгийн төсөв болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг иргэдийн оролцоотой төлөвлөн тэдний нэн тэргүүний хэрэгцээг хангахад зориулсан зарцуулалтыг шилэн болгоно.

8.4 Дулааны цахилгаан станц ашиглалтад орсноор жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлнэ.

8.5 Ажил эрхлээгүй, орлого багатай өрхийн иргэдийг мэргэжил ур чадвар олгох сургалтад хамруулж, хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр ажиллахад нь дэмжлэг туслалцаа үзүүлж хөдөлмөрийн зах зээлд зуучилна.


8.6 Бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, гарааны бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, өрсөлдөх хэмжээнд чадварыг дээшлүүлж ажлын байр, өрхийн орлогыг нэмэгдүүлнэ.



8.7 Хүнс, хөдөө аж ахуй, хүнд хөнгөн үйлдвэр, барилгын салбарын бага, дунд, эцсийн шатны бүтээгдэхүүн үйлдвэрлэх төслүүдийг хэрэгжүүлнэ.

ЕС. ШУДАРГА ЁСНЫ ЗАСАГЛАЛ

Тэгш хүртээмж - нээлттэй засаглал



- 9.1 Төр, иргэний нийгэм, хувийн хэвшлийн санал санаачилга оролцоо, хамтын ажиллагааг дэмжинэ.
- 9.2 Төрийн аливаа шийдвэр гаргалтад хүний эрхийн мэдрэмжтэй хандаж, аливаа хүнд суртлыг арилгана.
- 9.3 Төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол гэрээ хэлцэл, мэдээллийн санг хэвлэл, олон нийтэд нээлттэй ил тод болгоно.
- 9.4 Төрийн үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдэд тавих иргэний болон хөндлөнгийн хяналтыг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод шилэн байлгана.
- 9.5 Төрийн албан хаагчийн ёс зүй, хандлагыг ажлын гүйцэтгэлийн үнэлгээний салшгүй чухал хэсэг болгон хэвшүүлж, сэтгэл гарган үйлчлэх соёлыг дээшлүүлнэ.
- 9.6 Төрийн байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний талаар иргэд санал бодлоо цахим хэлбэрээр чөлөөтэй илэрхийлэх нөхцөлийг хангаж, цахим хэлэлцүүлгийн технологийг хөгжүүлнэ.
- 9.7 Хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрөөр хэрэгжиж байгаа ажил арга хэмжээнд дотоод аудитыг чанартай гүйцэтгэж, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлнэ.
- 9.8 Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 9.9 Төрийн албан хаагчийн тасралтгүй сурч хөгжих тогтолцоог бүрдүүлж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлж, нийгмийн баталгааны зохистой бодлогыг баримтална.
- 9.10 Гадаад хамтын ажиллагаатай улс, хот, мужуудтай тогтоосон харилцаагаа бэхжүүлж, түншлэлийн шинэ боломжийг нэмэгдүүлнэ.
- 9.11 Шаардлагатай тохиолдолд хотын эдийн засаг, тохижилт, нийгмийн өмнө тулгарч байгаа бэрхшээлүүд түүнийг шийдвэрлэх арга замын талаар асуулга боловсруулан ард иргэдээр эрэмбэлүүлэх, сонголт хийлгэх замаар иргэдийн оролцоог хангана.

Сүхбаатар сумын Монгол Ардын Намын хорооноос 2024 оны Сүхбаатар сумын ИТХ-ын сонгуульд оролцохдоо дэвшүүлж байгаа энэхүү хөтөлбөрт тусгагдсан хөгжлийн зорилтуудыг Сүхбаатар сумын ард иргэд та бид хамтран хэрэгжүүлэн, Ардын хувьсгалыг гардан хийж, Шинэ Монгол улсын эх суурийг тавьсан өвөг дээдэс, Их бүтээн байгуулалтын он жилүүдэд эх орноо аж үйлдвэржүүлж, атар газар эзэмшин хүн ардаа хүнсээр хангах амин чухал хэрэгцээг хангаж ирсэн ахмад үеийнхээ түүхэн уламжлалыг хадгалж, орчин цагийн шинэ техник технологи, инновацыг нэвтрүүлж хойч үеийнхээ ирээдүйн сайн сайхныг хамтран бүтээхийн төлөө Сүхбаатар сумаа "ХАМТДАА ХӨГЖҮҮЛБЭ".

